



ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/88

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн дотоод журам батлах тухай Г

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 130 дугаар зүйлийн 130.1, 130.2, "Эрүүл мэндийн хөгжлийн төвийн дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/21 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын 4 дүгээр зүйлийн 4.7.1, 4.7.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хөдөлмөрийн дотоод журам"-ыг нэгдүгээр, "Ерөнхий захирлын тушаалд санал авах хуудас"-ыг хоёрдугаар, "Чөлөөний хуудас"-ыг гуравдугаар, "Тойрох хуудас"-ыг дөрөвдүгээр, "Ээлжийн амралт олгох мэдэгдэх хуудас"-ыг тавдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тушаалыг батлагдан гарсан өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг нийт ажилтан, албан хаагчдад үүрэг болгосугай.

3.Тушаалыг танилцуулах, хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү, дотоод хяналтын албаны дарга /Т.Содгэрэл/-д даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Ерөнхий захирлын 2017 оны А/59, А/100 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ



Д.ГАНЦЭЦЭГ